



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/608

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Оюунцэцэгийн Уянга (СЮ02321840)-ийн эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр (Хэрлэн) баг, Тэмүүжингийн гудамж Ж-2 тоот хаягт байршилтай худалдаа, үйлчилгээний зориулалттай 1222 м2 газрыг Ханбүргэд хаан хоёр (4207092) ХХК-д 43 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Ханбүргэд хаан хоёр (4207092) ХХК-ийн эзэмшлийн газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Ханбүргэд хаан хоёр (4207092) ХХК-д үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/68 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ